# ОНЦГОЙ БАЙДЛЫН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛИЙН АНХДАГЧ НАЙРУУЛГЫН ТӨСӨЛ

Ажлын хэсэг

# ОНЦГОЙ БАЙДЛЫН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛИЙН АНХДАГЧ НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН БҮТЭЦ

- Нийт 9 бүлэг 52 зүйл / Нийтлэг үндэслэл- 1 бүлэг, 4 зүйл, Онцгой байдлын алба, түүний тогтолцоо, зохион байгуулалтын бүтэц- 1 бүлэг 15 зүйл, Онцгой байдлын албаны удирдлага, тэдгээрийн бүрэн эрх- 1 бүлэг, 6 зүйл, Онцгой байдлын албаны алба хаагч, түүний эрх, үүрэг- 1 бүлэг, 8 зүйл, Алба хаагчийн цалин хөлс, нөхөх төлбөр, тусламж болон нийгмийн баталгаа- 1 бүлэг, 5 зүйл, Албан тушаал эрхлэх болзол, журам алба хаагчийн хөдөлмөрийн харилцаа- 1 бүлэг, 8 зүйл, Онцгой байдлын албаны үйл ажиллагааны шуурхай байдлыг хангах-1 бүлэг, 1 зүйл,
-

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

Онцгой байдлын албаны санхүүжилт- 1 бүлэг, 3 зүйл, Бусад -1 бүлэг, 2 зүйлтэй./

БҮЛЭГ ТУС БҮРЭЭР ДЭЛГЭРҮҮЛЭН ТАНИЛЦУУЛЪЯ

# Нэгдүгээр бүлэг
## Нийтлэг үндэслэл

| **Зүйлийн нэр** | **Зохицуулалт / товчоор/** |
|---|---|
| Хуулийн зорилт | Хуулийн зохицуулах харилцаа |
| Онцгой байдлын албаны тухай хууль тогтоомж | Онцгой байдлын албаны хууль тогтоомжийн бүрдэл |
| Хуулийн үйлчлэх хүрээ | Хуулийн зохицуулах харилцааны хязгаарлалт |
| Хуулийн нэр томъёоны тодорхойлолт | Хууль хэрэглэгдэх зарим нэр томъёо тайлбарлагдсан |

# Хоёрдугаар бүлэг

## Онцгой байдлын алба, түүний тогтолцоо, зохион байгуулалтын бүтэц

| Зүйлийн нэр | Зохицуулалт / товчоор/ |
|---|---|
| Онцгой байдлын алба | Онцгой байдлын албаны тодорхойлолт, онцлог |
| Онцгой байдлын албаны туг, бэлгэдэл | Онцгой байдлын туг, бэлгэдлийн тухай, түүний эрх зүйн үндэс, хязгаарлалт |
| Онцгой байдлын албаны үндсэн чиг үүрэг | Онцгой байдлын албаны үйл ажиллагааны үндсэн чиглэл |
| Онцгой байдлын албаны нийтлэг зарчим | Холбогдох хуулиудад заасан нийтлэг зарчимаас гадна онцгой байдлын албанд зайлшгүй байх ёстой зарчимыг тусгасан |

# Хоёрдугаар бүлэг
## (Үргэжлэл -1)

| Зүйлийн нэр | Зохицуулалт / товчоор/ |
|---|---|
| Онцгой байдлын алба хаагчийн тангараг | Онцгой байдлын албаны албан хаагчийн тангараг, тангараг өргөх ёслолын журмын эрх зүйн үндэслэл |
| Онцгой байдлын албаны тогтолцоо | Албаны тогтолцоог тодорхойлж, орон тооны дээд хязгаар, байгууллагын бүтцийг тогтоох эрх зүйн үндэс |
| Онцгой байдлын төв байгууллага | Онцгой байдлын төв байгууллагын бүтцэд байж болох болон үндсэн нэгжүүдийг тогтоосон. Мөн төв байгууллагын харъяа нэгжүүдийг хэрхэн байгуулахыг зохицуулсан. |
| | |

# Хоёрдугаар бүлэг
## (Үргэжлэл -2)

| Зүйлийн нэр | Зохицуулалт / товчоор/ |
|---|---|
| Нутаг дэвсгэр хариуцсан онцгой байдлын байгууллага | Онцгой байдлын төв байгууллагын харьяа аймаг, нийслэл, дүүрэг дэх онцгой байдлын газар, хэлтсийн нэгжийн бүрдэл |
| Аврах анги, салбар | Аврах анги, салбарт байх нэгжийн тодорхойлж, үйл ажиллагааны эрх зүйн үндэс |
| Аюулгүй байдал -хяналтын нэгж | Аюулгүй байдал -хяналтын нэгжийн онцлог, үйл ажиллагааны чиглэл |

# Хоёрдугаар бүлэг
## (Үргэлжлэл -3)

| Зүйлийн нэр | Зохицуулалт / товчоор/ |
|---|---|
| Шуурхай удирдлага, зарлан мэдээлэх нэгж | Шуурхай удирдлага, зарлан мэдээлэх нэгжийн чиг үүрэг |
| Судалгаа шинжилгээний нэгж | Судалгаа шинжилгээний нэгжийн үйл ажиллагааг тодорхойлж, үйл ажиллагааны эрх зүйн үндэс |
| Сургалт дадлагын нэгж | Сургалт дадлагын нэгжийг байгууллага байхаар тогтоож, үйл ажиллагаа, үйл ажиллагаандаа мөрдөх хуулиудыг зааж өгсөн. |

# Хоёрдугаар бүлэг
## (Үргэжлэл -4)

| Зүйлийн нэр | Зохицуулалт / товчоор/ |
|---|---|
| Техник ашиглалт, засварын нэгж | Үйл ажиллагааны чиглэл, техник, хэрэгслийг бэлэн байдлыг хангахаар хүлээх үүргийг тодорхойлж өгсөн. |
| Эрүүл мэнд- сэргээн засах нэгж | Алба хаагчдад эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх үндсэн чиглэл, нэгжид байх хэсгүүдийг тодорхойлж, үйл ажиллагаандаа мөрдөх хууль, эрх зүйн үндэс |

# Гуравдугаар бүлэг
# Онцгой байдлын албаны удирдлага, тэдгээрийн бүрэн эрх

| Зүйлийн нэр | Зохицуулалт / товчоор/ |
|---|---|
| Засгийн газрын бүрэн эрх | Хуулийн зорилтын хүрээнд засгийн газрын хэрэгжүүлэх бүрэн эрх |
| Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх | Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний энэ хуулийн зорилтын хүрээнд хуульд заасанаас хэрэгжүүлэх бүрэн эрх |
| Онцгой байдлын албаны удирдлага | Онцгой байдлын албаны удирдлагын шинж, төв байгууллагын дарга, дэд дарга /тэргүүн дэд, дэд/, орон тооны бус зөвлөх ажиллуулах эрх зүйн үндэс |

# Гуравдугаар бүлэг
## (Үргэжлэл -1)

| Зүйлийн нэр | Зохицуулалт / товчоор/ |
| --- | --- |
| Онцгой байдлын төв байгууллагын бүрэн эрх | Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7.1-д зааснаас гадна хэрэгжүүлэх бүрэн эрх |
| Онцгой байдлын төв байгууллагын даргын үүрэг, бүрэн эрх | Онцгой байдлын төв байгууллагын даргын үүрэг, бүрэн эрх, нутаг дэвсгэр хариуцсан онцгой байдлын байгууллагын чиг үүрэг, зохион байгуулалтын бүтцийг тогтоох эрх зүйн үндэс, бүрэн эрхээ өөр албан тушаалтанд шилжүүлэх |

# Гуравдугаар бүлэг
## (Үргэжлэл -2)

| Зүйлийн нэр | Зохицуулалт / товчоор/ |
|---|---|
| Нутаг дэвсгэр хариуцсан онцгой байдлын байгууллагын бүрэн эрх | Нутаг дэвсгэр хариуцсан онцгой байдлын байгууллагын бүрэн эрхийг тогтоож, мөн байгууллагын дарга хууль тогтоомжид нийцүүлэн тушаал гаргах эрх |

# Дөрөвдүгээр бүлэг

# Онцгой байдлын албаны алба хаагч, түүний эрх, үүрэг

| Зүйлийн нэр | Зохицуулалт / товчоор/ |
|---|---|
| Алба хаагч | Онцгой байдлын албаны алба хаагч, Аврагчаас гадна аврах ажиллагаанд оролцох эрхтэй албан тушаалын ангилал, сумдад гамшгаас хамгаалах асуудал хариуцсан байцаагч ажиллах |
| Аврагч | Аврагчил тавигдах шаардлага, аврагчийн ангилал, Олон улсын аврах ажиллагаанд үүрэг аврагчийн багтай байж болох, Аврагчийн зөвлөл байгуулж болох зэрэг |
| | |

# Дөрөвдүгээр бүлэг
## (Үргэжлэл -1)

| Зүйлийн нэр | Зохицуулалт / товчоор/ |
|---|---|
| Аврагчийн мэргэжлийн зэрэг | Аврагчийн мэргэжлийн зэргийн ангилал, зэргийн шалгуур, зэргийн хугацаа |
| Аврагчийн тусгай хэрэгсэл | Үүрэг гүйцэтгэх үедээ тусгай зориулалтын хувцас, хэрэглэлээр хангагдах, эрх зүйн зохицуулалт |
| Алба хаагчийн цол, дүрэмт хувцас, ялгах тэмдэг | Офицер, ахлагчийн тэмдэг, албан үнэмлэх хэрэглэх, цолны ангилал, төв байгууллагын дарга цэргийн дээд цол олгож болох эрх зүйн үндэс |

# Дөрөвдүгээр бүлэг
## (Үргэжлэл -2)

| Зүйлийн нэр | Зохицуулалт / товчоор/ |
|---|---|
| Алба хаагчийн эрх | Төрийн албаны тухай хуульд заасан нийтлэг эрхээс эдлэх эрх |
| Алба хаагчийн үүрэг | Төрийн албаны тухай хуульд заасан нийтлэг үүргээс гадна хэрэгжүүлэх үүрэг, Алба хаагчийн сахилгын дүрмийн эрх зүйн үндэслэл |
| Алба хаагчид хориглох зүйл | Холбогдох хуулиас гадна хориглох зүйл |

# Тавдугаар бүлэг

## Алба хаагчийн цалин хөлс, нөхөх төлбөр, тусламж болон нийгмийн баталгаа

| Зүйлийн нэр | Зохицуулалт / товчоор/ |
|---|---|
| Алба хаагчийн цалин хөлс | Алба хаагчийн цалин хөлсний бүрдэл, аврагчийн мэргэжлийн зэргийн нэмэгдэл, суралцсан хугацааг ажилласан жил тооцох, Гамшгийн голомтод ажилласан алба хаачгийн томилолтын зардал |
| Алба хаагчид олгох нөхөх төлбөр | Албан үүргээ гүйцэтгэх үедээ эрүүл мэндээрээ хохирсон тохиололд алба хаагчид олгох нөхөн төлбөр, Улсын хяналтын байцаагч албан үүрэг гүйцэтгэх үедээ хувиасаа гарсан /таксинаас бусад/ зардлыг буцаан авах |
| | |

# Тавдугаар бүлэг
## (Үргэжлэл -1)

| Зүйлийн нэр | Зохицуулалт / товчоор/ |
|---|---|
| Алба хаагчид олгох тусламж | Үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алдсан алба хаагчийн ар гэрийн аль нэг гишүүнд 10 жилийн туршид сар бүр олгох, уг тэтгэмжийг хэнд олгох эрх зүйн үндэслэл, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас сүүлд нас барсан алба хаагчид дээрх тэтгэмж хамаарах, шилжин ажиллах шалтгаанаар эхнэр, нөхөр ажилгүй болсон бол ажил олгох, боломжгүй бол тусламж олгох зохицуулалт |

# Тавдугаар бүлэг
## (Үргэжлэл -2)

| Зүйлийн нэр | Зохицуулалт / товчоор/ |
|---|---|
| Алба хаагчийн баталгаа | Аймгийн төвөөс алслагдмал сумад тогтвортой ажиллаж байгаа алба хаагчид 5 жил тутам үндсэн цалинтай тэнцэх урамшуулал олгох, амь насны, үйлдвэрлэлийн болон гэнэтийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд заавал даатгуулах, Аврагч эрүүл мэндийн баталгаагаар хангагдах зохицуулалт |
| Алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмж | Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулиар зохицуулах |

# Зургаадугаар бүлэг

# Албан тушаал эрхлэх болзол, журам алба хаагчийн хөдөлмөрийн харилцаа

| Зүйлийн нэр | Зохицуулалт / товчоор/ |
|---|---|
| Албан тушаалд тавигдах шаардлага | Алба хаагчийн заавал эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, дадал, алба хаагчдад тавигдах тусгай шаардлага, эрх зүйн үндэс |
| Ээлжийн амралт | Ээлжийн амралтын үндсэн болон нэмэгдэл амралтын хугацаа |
| Алба хаагчийн алба хаах насны дээд хязгаар | Алба хаагчийн насны дээд хязгаар, ажиллах жилийг сунгах, ахлагчийн албан тушаал эрхэлж байгаа алба хаагчийг мэргэжлийн зэрэг туршлагыг харгалзан дахин сунгах, гэрээгээр ажиллах эрх зүйн үндэс |

# Зургаадугаар бүлэг
## (Үргэжлэл -1)

| Зүйлийн нэр | Зохицуулалт / товчоор/ |
| --- | --- |
| Алба хаагчийг томилох | Томилогдох иргэнд тавигдах шаардлага, шалгуур |
| Алба хаагчийг түр чөлөөлөх, чөлөөлөх | Төрийн албаны тухай хуульд зааснаас гадна түр чөлөөлөх, чөлөөлөх эрх зүйн үндэс |
| Алба хаагчид сахилгын шийтгэл ногдуулах | Төрийн албаны тухай хуулийн 26.1-д зааснаас гадна цол бууруулах буюу хураан авах сахилгын шийтгэл ногдуулах |
| | Төрийн албаны тухай хуулийн 31-р зүйлд зааснаас гадна олон хүний амь нас, эрүүл мэнд, их хэмжээний эд хөрөнгийг аюултай нөхцөл байдлаас авран хамгаалсан алба хаагчид мөнгөн урамшил олгох, бусад |

# Зургаадугаар бүлэг
## (Үргэжлэл -2)

| **Зүйлийн нэр** | **Зохицуулалт / товчоор/** |
|---|---|
| Алба хаагчийн шагнал, урамшил | Төрийн албаны тухай хуулийн 31-р зүйлд зааснаас гадна олон хүний амь нас, эрүүл мэнд, их хэмжээний эд хөрөнгийг аюултай нөхцөл байдлаас авран хамгаалсан алба хаагчид мөнгөн урамшил олгох, бусад |
| Алба хаагчийн хөдөлмөрийн бусад харилцаа | Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хуулиар зохицуулах |

## Долдугаар бүлэг

# Онцгой байдлын албаны үйл ажиллагааны шуурхай байдлыг хангах

| Зүйлийн нэр | Зохицуулалт / товчоор/ |
|---|---|
| Онцгой байдлын албаны үйл ажиллагааны шуурхай байдлыг хангах | Тээврийн хэрэгсэл дайчлах, холбоо, хэвлэл мэдээллийн хэрэгсэл ашиглах, тусгай дуут дохио хэрэглэх, үүрэг гүйцэтгэх явцад аливаа хэлбэрээр саад учруулахгүй байх, үйл ажиллагааны шуурхай байдлыг хангах бусад харилцааг процессийн тухай хуулиудаар зохицуулах |
| | |

# Наймдугаар бүлэг
# Онцгой байдлын албаны санхүүжилт

| Зүйлийн нэр | Зохицуулалт / товчоор/ |
|---|---|
| Онцгой байдлын албаны төсөв | Албаны төсвийн зохицуулалт |
| Орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга нь тодорхой зардлыг орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлж болох |
| Онцгой байдлын албаны хөгжлийн сан | Албаны материаллаг баазыг бэхжүүлэх, үүрэг гүйцэтгэх чадавхийг нэмэгдүүлэх, алба хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор хөгжлийн сантай байх |

# Есдүгээр бүлэг
## Бусад

| Зүйлийн нэр | Зохицуулалт / товчоор/ |
|---|---|
| Онцгой байдлын албаны тухай хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага | Онцгой байдлын албаны тухай хууль тогтоомж, өргөсөн тангаргаа зөрчсөн онцгой байдлын албаны алба хаагчид холбогдох хуулийн дагуу хариуцлага ногдуулах |
| Хууль хүчин төгөлдөр болох | Хууль дагаж мөрдөх огноо |

# Анхаарал тавьсанд баярлалаа